

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ХУУЛИЙН 12.1.3-Т ЗААСАН “АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ” ЖУРМЫН ТӨСӨЛ ДЭЭР ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЪЁОГ

№	Санал ирүүлсэн байгууллага	Ирүүлсэн санал	Тусгасан эсэх
1.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	1.4-т "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангах ажлыг энэхүү журамд заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институттэй хамтран зохион байгуулна." гэх	Саналыг тусгасан бөгөөд журмын 1.4 дэх заалтыг өөрчлөн найруулсан
2.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	3.5-д "Энэхүү журамд заасан үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хүсэлт гаргасан хохирогчид хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийж, тухайн иргэний ур чадвар, онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/, холбогдох сургалтад хамруулах, ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулна." гэх	Саналыг тусгасан бөгөөд журмын 3.5 дахь заалтыг өөрчлөн найруулсан
3.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	3.8-д "Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага зохих мэргэжилтэй, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн, хөдөлмөр эрхлэлтийн болон мэргэжлийн сургалтад хамрагдсан хохирогчийг нэн даруй ажлын байранд зуучилна." гэх	Саналыг тусгасан бөгөөд журмын 3.5 дахь заалтыг өөрчлөн найруулсан
4.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	3.9-ийг хасах	Саналыг хүлээн авч холбогдох заалтыг хассан

5.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад журмын хэрэгжилтийн сарын тайлан мэдээг дараа сарын 3-ны дотор, улирлын тайлан мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны дотор, Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлд сарын тайлан мэдээг дараа сарын 3-ны дотор, улирлын тайлан мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны дотор тус тус хүргүүлнэ."	Саналыг тусгасан бөгөөд журмын 6.2 дахь заалтыг өөрчлөн найруулсан
6.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	6.5-д "Журмын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт хагас, бүтэн жилээр хийж, тухай бүр холбогдох байгууллагад тайлагнана." гэх	Саналыг тусгасан бөгөөд журмын 6.5 дахь заалтыг өөрчлөн найруулсан